

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ,
ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН М.МӨНХТУУЛЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
НЭГ. “ДОТООД ХЯНАЛТЫН ҮЙЛ ЯВЦЫН ҮР НӨЛӨӨТЭЙ БА ҮР АШИГТАЙ БАЙДЛЫГ ҮНЭЛЭН БАЙНГЫН САЙЖРУУЛАЛТЫГ САНАЛ БОЛГОХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД.							
1.	Арга хэмжээ 1.1 Байгууллагын 2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх.	ХШҮХ танилцуулгын тоо	-	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2022-2024 стратеги төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж 94.1 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн. Стратеги төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тайланг ЦХИХХЯамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэлийг хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийн хамт Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/221 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	2025.02.01-2025.03.01	100%

2.	Арга хэмжээ 1.2 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн 2024 оны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх.	ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газарт ХШҮХ танилцуулгыг хүргүүлэх.	-	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн 2024 оны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэлийн хамт ЦХИХХСайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 03/513 дугаар албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Мөн Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан new.unelgee.gov.mn -д хуулийн хугацаанд тайлагнасан.	2025.03.01	100%
3.	Арга хэмжээ 1.3 Гадаадын зээл тусламж, гадны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гарган, сангийн яамд тайлагнах.	ХШҮХ тайлан, Дүгнэлт зөвлөмжийн тоо	-	1	ЦХИХХЯамнаас гадаадын зээл тусламж, гадны хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлж буй “Ухаалаг засаг-2” төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, дүгнэлт, зөвлөмжийг ЦХИХХСайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/520 дугаар албан бичгээр Сангийн яамд хүргүүлсэн.	2025.03.01-04.01	100%
ХОЁР. “САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ЗӨВЛӨМЖ ГАРГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
4.	Арга хэмжээ 2.1 Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа болон салбар байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөмж дүгнэлт гаргах.	Үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байгууллагын тоо	-	1	ЦХИХХСайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шалгалт хийх ажлын хэсгийг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар байгуулж, хяналт шалгалтын удирдамжийг батлуулсан.	2025.04.01-2025.05.01	100%

					Батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг “Монголын Цахилгаан холбоо” ХК-д 2025 оны 02 дугаар сарын 25-наас 03 дугаар сарын 30-ны хооронд хийж, хяналт шалгалтын тайлан, дүгнэлт зөвлөмжийг ЦХИХХСайдын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/878 дугаар албан бичгээр хүргүүлсэн.		
4	Арга хэмжээ 2.2 Сайдын эрхлэх асуудлын хүрээний салбар, харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах.	Агентлаг болон харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд ХШХ тайлан	-	3	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, “Үндэсний Дата төв” УТҮГ, “Кибер халдлага зөрчилтэй тэмцэх Нийтийн төв” “Кибер аюулгүй байдлын” “Кибер аюулгүй байдлын зөвлөл” гэсэн нийт 4 харьяа болон салбар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тайлан, дүгнэлт зөвлөмжийг ЦХИХХЯамны удирдлагын зөвлөлийн хурлаар 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хэлэлцүүлж танилцуулан, дүгнэлт зөвлөмжийг салбар болон харьяа нийт 7 байгууллагад тус тус хүргүүлсэн.	2025.02.01	100%
ГУРАВ.“АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ЗӨВЛӨМЖ ГАРГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
5.	Арга хэмжээ 3.1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө №139 Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх. (Нийслэл, 10 аймаг)	ЗГХЭГ-ын цахим санд журмын хугацаанд тайлагнасан байх.	-	11	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 86.2 хувьтай үнэлэгдсэн. ЦХИХХСайдтай байгуулсан гэрээний Нийслэл болон 10 аймгийн биелэлтийг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Засгийн	2025.03.01	100%

					газрын Хэрэг эрхлэх газрын Цахим сан болон new.unelgee.gov.mn-д хуулийн хугацаанд тайлагнасан.		
ДӨРӨВ. “ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
	Арга хэмээ 4.1 Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлагын нөлөөллийн шинжилгээ хийх.	Нөлөөллийн шинжилгээ хийсэн танилцуулга	-	1	Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлагын нөлөөллийн шинжилгээ Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлагын нөлөөллийн шинжилгээг суурь судалгаанд үндэслэн боловсруулж дууссан. Нөлөөллийн шинжилгээг Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссд танилцуулсан.	2025.04.17- 2025.06.30	100%
6.	Арга хэмжээ 4.2 Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлагын журмын төслийг боловсруулах.	Боловсруулсан журмын төслийн тоо	-	1	“Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага”-ын журмын төслийг 2023-2024 оны суурь судалгаа, холбогдох баримт материалуудад үндэслэн боловсруулж дууссан. “Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага”-ын журмын төсөлд Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, Хууль зүйн яам, холбогдох салбарын мэргэжлийн байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэмэлт байдлаар тусган боловсруулж дууссан. 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар ЦХИХХСайдын журам батлуулах тушаалын төслийг боловсруулж, тушаалын төсөлд санал авч байна.	2025.06.30	100%

ДӨРӨВ: “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД.							
7.	Арга хэмжээ 4.1 Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнах.	Хэрэгжилтийн хувь	-	100%	Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хуулийн хугацаанд батлуулж, тайлагнасан.	2025.01.02-2025.06.15	100%
8.	Арга хэмжээ 4.2 Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх.	Хэрэгжилтийн хувь	-	100%	Төрийн байгууллагаас ирсэн нийт 56 албан бичигт хууль, холбогдох журамд заасан хугацааны дагуу хариуг хүргүүлснээс 34 бичиг нь Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгсөн бичиг байна.	2025.01.02-2025.06.15	100%
9.	Арга хэмжээ 4.3. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Хэрэгжилтийн хувь	-	100%	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу Хөрөнгө оруулалтын мэдүүлгийг хуулийн хугацаанд тайлагнасан.	2025.02.01-2025.02.15	100%
10.	Арга хэмжээ 4.4. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь, чанартай гүйцэтгэх, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх.	Хэрэгжилтийн хувь	-	100%	Нэгжийн даргаас өгсөн үүргийн дагуу КАББЗГ-ын өдрийн тайланг 2025 оны 04 дүгээр 17-ны өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар өдөр болгон бичиж нэгжийн даргад тайлагнасан. КАББЗГ-ын сарын тайланг ТЗУГ-т тухай бүр тайлагнасан. Мөн ЦХИХХСайдын 2025 оны А/52 дугаар тушаалаар баталсан үүрэг даалгаврын хэрэгжилтийг ЦХИХХСайдын ажлын	2025.01.02-2025.06.15	100%

					албанд хүргүүлсэн. Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газрын шинээр санаачлан хийсэн ажлын тайланг ЦХИХХСайдын ажлын алба болон Төрийн Захиргааны удирдлагын газарт тус тус хүргүүлсэн. Мөн Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газрын сүүлийн 10 сар хийсэн ажлын тайланг ЦХИХХСайдын ажлын алба болон сайдын Зөвлөх М.Тулгатад хүргүүлсэн. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулагдсан Онц чухал дэд бүтэцтэй байгууллагын албан хаагчдад зориулсан “Онц чухал мэдээллийн дэд бүтцийн кибер аюулгүй байдал” сэдэвт арга хэмжээнд Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газрын даргын илтгэх танилцуулга болон ppt-г бэлтгэсэн. Соёл спорт аялал жуулчлалын яамнаас Залуучуудын хууль батлуулах ажлын хэсэгт орж ажиллан Залуучуудын хуулийн төслийн нөлөөллийн шинжилгээнд ЦХИХХЯамыг төлөөлөн холбогдох саналыг өгч ажилласан. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх 3 журмын төсөлд санал боловсруулж хүргүүлсэн. ЦХИХХСайдад Монголын Цахилгаан холбоо ХК-ны хяналт шалгалтын танилцуулга ppt бэлтгэн 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр танилцуулсан.		
--	--	--	--	--	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

	Арга хэмжээ № 1.1 Удирдлагын Академи болон Кибер аюулгүй байдлын аудит, мэдээллийн системийн аудитор бэлтгэх сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдаж сертификат авсан байна	-	1	Удирдлагын академи болон Сангийн яамнаас зохион байгуулсан гадаадын зээл тусламж болон төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа төслийн 3 өдрийн сургалтад хамрагдаж сертификат авсан. Мөн Батлан хамгаалахын яамнаас зохион байгуулж байгаа Кибер аюулгүй байдлын аудит, мэдээллийн системийн аудитор бэлтгэх 150 цагийн сургалтад хамрагдаж байна.	2025.06.15	100%
	Арга хэмжээ № 1.2 Байгууллагаас болон бусад газраас зохион байгуулсан сургалтад хамрагдах.	Сургалтад хамрагдсан байна.	-	3	Засгийн газрын хэрэг эрхлэх газраас БНСУ-ын төрийн академитай хамтран 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан сургалтад хамрагдсан. Сангийн яамнаас зохион байгуулсан “Төсөл хөтөлбөр болон гадны зээл тусламжаар хэрэгжиж буй хөтөлбөрийн тайлан гаргахтай” холбоотой сургалтад хамрагдсан. “Төрийн албан хаагчийн сургалт нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн сургалтад 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр хамрагдсан. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Хууль зүйн яаман дээр зохион байгуулсан Хяналт-шинжилгээ, үнэлгээний сургалтад хамрагдаж холбогдох чиглэлээр саналууд өгсөн.	2025.06.15	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ, ДОТООД
АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

..... /М.МӨНХТУУЛ/
(Нэр, гарын үсэг) (Огноо)

2025.06.05